

“ҮНДСЭН ХУУЛИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ОНОЛ, АРГА ЗҮЙ БА ОРЧИН ҮЕ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

Эрдэм шинжилгээний хурлын зорилго: Үндсэн хуулийн процессын эрх зүйн онолын суурь үзэл баримтлал, арга зүйн ондоошил, судалгааны чиг хандлагын харьцуулсан судалгааны үндсэн дээр Үндсэн хуулийн хэрэглээний онол, арга зүй, шинжлэх ухаан, практикийн асуудал, Үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэж буй нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлэлт өгөх, цаашид Үндсэн хууль хэрэглэх онол, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход оршино.

Эрдэм шинжилгээний хурлын ач холбогдол: Үндсэн хуулийн хэрэглээний онол-арга зүйн хөгжлийг задлан шинжлэх, түүний хэрэглээний орчин үеийн чиг хандлагыг тодорхойлж, Үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг гүнзгийрүүлэн судлахад хувь нэмэр оруулна.

Эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцэх асуудлын хүрээ:

А. Нийтлэг асуудал, онолын үндэс, арга зүйн асуудал:

- Үндсэн хуулийн хэрэглээний эзлэх байр суурь;
- Үндсэн хуулийн зарчим, түүний шинж чанар онолын болон хэрэглээний талаас авч үзэх;
- Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргалтын дараах нөлөөллийн судалгаа;
- Үндсэн хуулийн шүүх шийдвэрээсээ буцах онолын болон эрх зүйн зохицуулалтын үндэс, ач холбогдол;
- Ази, дорно дахины Үндсэн хуулийн соёл.

Б. Хэрэглээ ба практик үр нөлөө

- Харьцуулсан Үндсэн хуулийн хэрэглээний онол, эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжийн шинэчлэлд ашиглах нь;
- Үндэсний эрх зүйн тогтолцоог сайжруулахад оруулж буй хувь нэмэр;
- Азийн болон бүс нутгийн эрх зүйн уялдаа, интеграци;
- Монгол Улсын үндсэн хуулийн процессын хөгжилд харьцуулсан судалгааны нөлөө, үр дүн.

Хуралд оролцогч нар:

Хууль зүйн их сургуулийн эрдэмтэн, судлаачид, хууль зүйн салбарын мэргэжилтэн, ахисан түвшний сургалтын хөтөлбөрт суралцагсад.

Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах өдөр, газар:

Эрдэм шинжилгээний бага хурлыг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр 09-13 цагийн хооронд Монголын Хуульчдын холбооны Хуульчдын танхимд зохион байгуулна.

Илтгэлийн бичлэгт тавигдах шаардлага:

- Хурлын зорилго, агуулгын хамрах хүрээнд нийцсэн байна.
- Нэг буюу хамтран судлаачтай байж болно.
- Өмнө нь хурлаар хэлэлцүүлээгүй, нийтэлж хэвлээгүй шинэ судалгааны үр дүн байна.
- Илтгэлийг монгол, англи, орос хэлээр бичиж ирүүлж болно.
- Илтгэл нь хураангуй, түлхүүр үг, оршил, үндсэн агуулга, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгээс бүтсэн, 8-10 хуудастай байна.
- Эшлэлийг APA стандартаар хийж, зохиогчийн эрхийн зөрчилгүй байвал зохино.

Илтгэл, мэдүүлэг хүлээн авах хугацаа:

Хуралд оролцогчдын мэдүүлэг, илтгэлийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор Gunbileg.work@gmail.com цахим шуудангийн хаягаар хүлээн авна.

Хугацаа хожимдсон, шалгуур хангаагүй илтгэлийг хүлээн авахгүй.

Илтгэгчдийн ирүүлсэн бүтээлийг хуулбарлалтын Turnitin программаар шалгаж, зохиогчийн эрхийг хамгаалах болно.

Шаардлага хангасан илтгэлийг эмхэтгэнэ.

Мэдүүлгийг дараах хэлбэрээр ирүүлнэ:

- Овог нэр
- Илтгэлийн сэдэв
- Эрдмийн зэрэг, цол
- Ажлын газрын хаяг, албан тушаал
- И-майл хаяг
- Холбоо барих утасны дугаар

Эрдэм шинжилгээний бага хуралтай холбоотой мэдээллийг 95800707 дугаартай утсаар холбогдож авна уу.

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН,
БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХОРОО**